



СЭЛЭНГЭ АЙМАГ
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/92

Алтанбулаг

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "а" заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4, 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8, 12 дугаар зүйлийн 12.1, 22 дугаар зүйлийн 22.2, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Үйлчилгээний жишиг үнэлгээ тогтоох тухай" 41 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/101 тоот захирамж, Сум, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны "Үйлчилгээний зардлыг тогтоох тухай" 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийгмийн эрүүл мэнд, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах, мал амьтны өвчлөлийн байдлыг бүртгэх, мэдээлэх, ажил үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах, хяналт тавих зорилгоор сумын хэмжээнд Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга
Гишүүдэд

Ү.Янжиндулам (ЗДТГ-ын дарга)
О.Чинчимэг (МЭУБайцаагч)
Б.Баттулга (1 дүгээр багийн Засаг дарга)
Г.Жамбалдорж (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Ган-Эрдэнэ (Тархвар зүйч)
Г.Мөнхболд (ХАА-н тасгийн мэргэжилтэн)
Р.Булгаа (МЭҮН-ийн малын эмч)
Л.Гантөмөр (МЭҮН-ийн малын эмч)

2. Ажлын хэсгийн дарга, гишүүдэд Даалгах нь:

2.1. Лабораторийн оношлогоо, шинжилгээ, дархлаажуулалт, угаалга, туулгалт, боловсруулалтад эрсдэлтэй бүсийн мэдрэмтгий мал, амьтныг технологит хугацаанд бүрэн хамруулах.

2.2. Гоц халдварт өвчний голомт бүхий нутгаас мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэх, тууварлах, шаардлагагүй нөхцөлд

голомт бүхий аймаг, сумдад зорчуулахгүй байх, хүн, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд байнга хяналт тавьж ажиллах.

2.3. Дархлаажуулалт, шимэгчтэх, халдваргүйтгэлийн нэгдсэн арга хэмжээний дагуу мал эмнэлгийн нэгдсэн цахим системийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус тус даалгасугай.

3. Био бэлдмэл, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих, суманд нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг сумын Засаг даргын зөвлөлд тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч /О.Чинчимэг/-т үүрэг болгосугай.

4. "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ"-ний явцад хариуцлагагүй хандсан хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх, хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга /У.Янжиндулам/-д, Мал эмнэлгийн улсын байцаагч /О.Чинчимэг/ нарт үүрэг болгосугай.

4. Зохион байгуулах ажилд шаардагдах зардлыг Засаг даргын нөөцөөс гаргахыг төсвийн нягтлан /Р.Насанжаргал /-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ОТГОНЦОГТ